“ДЭЭРЭЭС ТОГТООСОН ДҮРСИЙН ТУС БҮРИЙГ БҮРТГЭСЭН БИЧИГ” БҮТЭЭЛИЙГ СУРГАЛТАД ХЭРЭГЛЭЖ, ХАДГАЛЖ БАЙСАН МААРАМБЫН АЛДАР, ЦАДИГИЙГ СУДЛАХУЙ

Гэрэлмаа.Б[1], Шагдарсүрэн.Д[2], Б.Дагданбазар[1], Болд.Ш[3]
[1]“Ач” АУИС, [2]ЭЗШУИС, [3]МАУА
E-mail: boldshrv@gmail.com

Abstract

RESEARCH ON THE BIOGRAPHY OF THE MAARAMBA WHO PRESERVED AND USED “COMPLETE RECORD OF THE BODY BY IMPERIAL ORDER” IN TRAINING

Gerelmaa.B[1], Shagdarsuren.D[2], Dagdanbazar B[1], Bold.Sh[3],
[1]“Ach” Medical University, [2]Mongolian University of Pharmaceutical Sciences
[3]Mongolian Academy of Medical Sciences,
E-mail: boldshrv@gmail.com

Background

In the source materials of our research work, there is a mention of a mysterious unknown person who safeguards and teaches books. By virtue of his efforts, the important medical scripture “Complete Record of the Body by Imperial Order” was used in the training of doctors in Mongolia, as well as all the discoveries and achievements of science discovered in Europe at that time. It is the foundation of all medical achievements as we know them today.

Research goal

To identify the custodian of the source mentioned in the foreword of the book “Complete Record of the Body by Imperial Order” published by academician Rinchen.B.

Research methods

Methods of historical analysis, comparative research, and examination of source materials were used in the research.

Conclusion

1. In his foreword to the 2 volumes and 6 sections of the work “Complete Record of the Body by Imperial Order” published in 1971, Rinchen.B mentioned the person who kept it in Ulaanbaatar as the owner, without mentioning the name and vaguely. The individual was identified as the Vice head monk of Manba Datsan of Zuun Khuree, Da Rinbuchi, the famous Jasyn Damdin agramba (maaramba).
2. Thanks to the order of Eighth Bogd Jebtsundamba Khutuktu and the efforts of Jasyn Damdin agramba (maaramba), this principal medical scripture was used in the Manba Datsan training course in Mongolia. It is believed that the achievements of the medical science discovered in Europe at that time, written in the work, became another important fact of teaching the students of the medical school, and then of the repeated attempts to integrate Western and Eastern medicine.

Keywords: medical scripture, discoveries, Manba Datsan, maaramba, Western and Eastern medicine

Үндэслэл

Бидний судалгааны ажлын эх хэрэглэгдэхүүнд нэгэн учир битүүлэг нэр нь үл мэдэгдэх, номыг хайрлан хамгаалагч, хойч үедээ уламжлан дамжуулагч, бүтээлчээр сургалтад ашиглагч, журам ёсыг баримтлагч эрхэм дээд хүмүүний тухай дурдагдсан юм. Тэр хүмүүний ачаар анагаах ухааны

энэ чухал судар Монгол Улсад эмч бэлтгэх сургалтад ашиглагдаж, тухайн үеийн Европт нээгдсэн шинжлэх ухааны бүхий л нээлт, ололт амжилтыг цаг алдалгүй тухай бүрт нь эмч нартаа заан сургаж, улмаар та бидний мэдэх одоогийн анагаах ухааны ололт амжилт бүхний суурь үндэс болсон ажээ.

“Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”-ийг (1971) эрхлэн хэвлүүлсэн Б.Ринчен уг хэвлэлийн өмнөх үгэндээ: *“Судар бичгийн хүрээлэнгийн дарга Жамьян гүн (1864-1930) ном судрын зүйлийг эрэн сураглаж, Бээжингээс Наянт вангийнд байсан монгол барын Данжуур олж ирэхийн хамт, Бээжинд Жанжаа хутагтын номын санд байсан сураг гаргаж, түүнийг Ар Монголд авааччсан ул мөрийг нь хөөсөөр, Улаанбаатарт хадгалан буй эзнийг нь олоод (хэн гэдэг ямар хүн гэдэг нь тодорхойгүй), Хүрээлэнгээс байгуулсан Улсын номын санд авч хадгалах гэхэд, Зүүн хүрээний Мамба дацан гэдэг энэтхэг төвөд эмийн сургуульд үзэн хэрэглэж байсан тул, эзэн нь (хэн гэдэг ямар хүн гэдэг нь тодорхойгүй) Улсын номын санд шилжүүлэхгүй гэсэн учраас, чухлыг нь бодож, өөрөө хулсан үзгээр нэгэн хувь сийрүүлж, уг эх бичгийн доторх зураг маш нарийн тул, гэрэл зураг татан буулгах нарийн багаж хараахан дутмаг байсан учраас, Судар бичгийн хүрээлэнгийн байгуулсан Улсын музейн эрдэмтэн, хадгалагчаар ажиллаж байсан Зөвлөлтийн эрдэмтэн Лисовскоор эх зураг дээр нь нимгэн цаас тавиулан хуулуулж, сийрүүлэн хувьдаа наалдуулан үлдээсэн билээ. Сүүлд уг эх бичиг нь номын санд шилжин ирээд, энэ завсар тэргүүн дэвтэр нь алдагдсан учир, эл сонин чухал бичгийн тэргүүн дэвтрийг нь Жамьян гуайн хуулсан, Лисовскийн зурсан зурагт дэвтрээр, бусдыг нь уг эх бичгээс зураг татан үүнээ нийтлэхдээ, анх яаж олсон түүхийг нь дурдан тэмдэглэж, судлан үзэх хүмүүст уламжиллаа”* хэмээн бичсэн байдаг [1].


Анагаах ухааны түүх бол өнгөрснийг судалдаг. Өнгөрснийг судлахын зэрэгцээ өнөөгийн анагаах ухаан хэрхэн бүрэлдэн бий болсон, энэ үйл явцад ямар ямар өөрчлөлтүүд нөлөөлснийг ойлгох боломжийг олгодог.

Зорилго

Академич Б.Ринчен гуайн хэвлүүлсэн “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” номын хэвлэлийн өмнөх үгэнд дурдсан тус сурвалжийн тухайн үеийн хадгалан хамгаалагчийг олж тогтоох.

Судалгааны арга

1. Түүхийг шинжлэн судлах аргыг ашигласнаар өнгөрсөн үйл явдлыг судалж өнөөгийн анагаах ухаан хэрхэн бүрэлдэн бий болсон, энэ үйл явцад юу нөлөөлж, хэрхэн өөрчлөгдсөнийг танин мэдэх боломжийг олгоно. Ингэснээр анагаах ухааны түүх, хөгжлийн өнгөрсөн болон өнөө үеийн байдал, орон зай, цаг хугацааны өөрчлөлтийн хүрээн дэх зүй тогтлын тухай шинжлэх ухааны баримтуудыг цуглуулж, нэгтгэн дүгнэх боломжийг олгодог. Бид ч энэхүү судалгааны аргыг үндсэн эх сурвалжид дурдагдсан нэр нь үл мэдэгдэх, судар номыг хайрлан хамгаалагч, хойч үедээ уламжлуулагч, журам ёсыг баримтлагч нэгэн эрхэм хүний түүхэн үйл явдлыг тодруулахад ашиглав.
2. Харьцуулан судлах аргыг хоёр өөр баримтыг харьцуулан адил болон ялгаатай талыг тодруулахад хэрэглэв.
3. Эх сурвалжтай ажиллах арга нь эртний хүмүүсийн амьдралын ул мөрийг хадгалсан түүхийн эх сурвалжуудыг судлах арга юм. Энэ аргын дотроос эд өлгийн болон бичгийн эх сурвалжуудыг судлах аргыг судалгаандаа ашиглалаа.



Зураг 1. Эх сурвалжийн төрлүүд

Судалгааны үр дүн

Жамьян гүний эртний анагаах ухааны уг эх бичгийг эрэн хайх судлан сурвалжлах ажил нь Олноо өргөгдсөн 11-р оны 10 дугаар сарын 1-ний өдөр тавигдсан байна. Учир нь энэ өдөр Ардын засгийн газраас 3000 лан мөнгийг гаргаж Монгол Улсын энэ ба ирээдүй хойчид хэрэг болох “Гадаад олон улсын, зүйл бүрийн ухааны хийгээд төр, улсад хэрэг болох ном судрыг олж авах, монгол үсгээр орчуулах” тухай 24-р тогтоол гарчээ. Энэ 24-р тогтоолын хүрээнд Жамьян гүн олон арван эрдэм мэдлэгтэй лам, хар, тайж ноёдтой уулзаж, түмэн бичиг баримт сөхөн уудлан судалсны дүнд “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”-ийг Бээжин дэх Жанжаа хутагтын номын санд байгааг илрүүлсэн хэмээн үзэж байна. Энэхүү ховор эх бичгийг Монгол орондоо цуглуулан бий болгох ажлыг ганц Жамьян гүнд даатгаагүй бөгөөд тухайн үедээ хамгийн эрдэм номтой эрэлч, хайгуулч, эрдэмтэн, түшмэл нараас бүрдсэн дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй баг гаргажээ. Багийн гишүүдэд:

1. Түшмэл Жамсранов
2. Сайд Гүн Жамьян
3. Гүн Дашням
4. Түшмэл Бат-Очир нар багтсан ажээ.

“Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”-ийн 1971 онд дахин хэвлүүлсэн хэвлэлийн өмнөх үгэнд Б.Ринчен гуайн зөвхөн Жамьян гүн тухайн номыг эрж хайж байсан талаар дурдсан хэдий ч үнэн хэрэгтээ монгол эрдэмтдийн баг энэ үйл хэрэгт оролцсон нь Олноо өргөгдсөн 11 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн Ардын засгийн 24 -р хурлын 3-р зүйлд тэмдэглэгдэн үлдсэн байна [2].

Жамьян гүн нь Жонон ван Ширнэндамдин, хэлмэрч Хишигт нарыг дагуулан 14 оны 10 дугаар сарын шинийн 3-наас 15 оны 4 дүгээр сарын 6-н хүртэл 6973 төгрөг 15 мөнгө зарцуулан Бээжин, Шанхай, Өвөр Монголын нутгаар явж манж, хятад, англи, төвөд хэлээр хэвлэгдсэн ховор нандин судар ном цуглуулсны дотор Монгол данжуурын бүрэн боть л гэхэд үхэр тэргэнд ачихад 16, тэмээнд ачихад 25 тэрэг болсон гэдэг.

Энэ их урт удаан цаг хугацаа, хүч хөдөлмөр, мөнгө төгрөг зарцуулсан судалгаа, хайгуулын аян замд Жамьян гүн Монголд байхдаа анхнаасаа “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”-ийн сургийг Бээжин дэх Жанжаа хутагтын номын санд байгааг мэдэж эх хувиар нь эсвэл хувилж авахаар очсон боловч Бээжинд ирсэн хойно уг номыг олж авч чадаагүй ч аль хэдийн Ар Монголд очсон сургийг нь гаргаж чаджээ. Магадгүй энэ ном Жамьян гүнг очихоос өмнө Богд хааны зарлигаар Ар Монголд залагдаж Наймдугаар Богдын шууд удирдлагад байдаг Зүүн хүрээний Мамба дацангийн сургалтад хэрэглээнд ороод нэлээд хэдэн жилийн нүүрийг үзсэн байж болох нь цаг хугацааны түүхэн явдлын учир зүйгээс тодорхой харагдаж байгаа юм.

Дээрх баримтуудаас дүгнэж үзэхэд бидний үед энэхүү ховор ном ямар их олон хүний хүчин зүтгэл, зардал мөнгөөр эрэл хайгуул болж байсныг гэрчлэх юм. Харин Ринчен гуайн бичиж тэмдэглэсэн Монголд аль хэдий нь энэ номыг олж авчраад сургалтад хэрэглүүлж байсан хүн нь хэн бэ? гэдэг асуултын хариуг олохын тулд тухайн үеийн төр, шашны тэргүүн, зарим хүмүүс, тэдний үйл хэргийг судлах шаардлагатай болсон юм.

Зүүн хүрээний Мамба дацанд “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээлийг үзэж байх үед улсын хэмжээний эрүүл мэндийн удирдах ажилтан хэн байв? Эх сурвалжаас үзэхэд [3] 1921 оны 7-р сарын 10-нд Жавзандамба хутагтыг Монгол Улсын хэмжээгүй эрхт хаанаар өргөмжлөгдөх үед Сэцэн хан аймгийн Дайчин бэйсийн хошууны Баяд отгоос гаралтай Дарьзавын Лосол (1889-1940) нь 1923-1925 онд “Цэрэг, ардыг эмчлэх хороо”-ны эрхэлсэн түшмэл (дарга)-ийн албан тушаалыг хашиж байв. Тиймээс Д.Лосол түшмэл энэхүү номын талаар сайн мэдэхийн зэрэгцээ Жамьян гүнтэй ярилцан хуулан авч үлдэхийг нь ихэд дэмжсэн бололтой хэмээн таамаглаж болохоор байна. Учир нь Д.Лосол, Жамьян гүний хүргэн байсан тухай, Монголын дотоод дахь байдал, засаг төрийн доройтлын тухай Бодоогийн хамт Жамьян гүний гэрт хэлэлцдэг байсан талаар Ш.Чоймаа багшийн дурсамжид бий [4].

1939 оны 7 дугаар сарын 15-нд Хувьсгалын эсэргүү байгууллагад оролцогч хэмээн баривчлагдаж, ЗХУ-ын Чита, Москва хотод шорон дамжин байцаагдаж, Бутырын шоронд өвчнөөр нас баржээ. ЗСБНХУ-ын Ерөнхий прокурорын 1956 оны 11 дүгээр сарын 24-д баталсан тогтоолоор Д.Лосолд холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй хэмээн хэрэгсэхгүй болгосныг үндэслэн

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн газрын дэргэдэх Цагаатгах ажлыг эрхлэх Улсын комиссын 1962 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 78 дугаар тогтоолоор цагаатгажээ.

“Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”-ийг Зүүн хүрээний эмчийн сургуульд судалж байх түүхэн он цагт дэд хамбаар нь Бутачийн Дамдин хэмээх аграмбын мяндагтай эрдэмт лам ажиллаж байжээ. Тэрбээр 1000 шахам шавьтай, Төв аймгийн Баянцогт сумын харъяат бөгөөд найман наснаас эхлэн Зүүн хүрээнд шавилан суусан улмаар дацангийн унзад, цоржийн зэрэг тушаалтай мөн Гандан ба Зүүн хүрээний дэд хамбын тушаалтай эрдэмт хуварга байв [5].

Музейн ахмад ажилтан Н.Дэндэвийн дурдатгалд: “1924 онд Богдын ногоон ордны эд зүйлсээр музей байгуулах тогтоол гарсан юм. Тэр үед Богдын ногоон ордноос маш их ном гарсан юм. Үүнээс гадна Жасын Дамдин цорж ламын номыг цөмийг авлаа. Лав 2-3 машин ном байлаа. Ер нь Дамдин цорж их номтой байжээ. Түүний шавь Пунцагцэрэн жасын багшид ном эрснээс, говьд тэмээ эрсэн нь дээр гэдэг байсан” хэмээн өгүүлжээ [6].

Дэд хамба Дамдин ба Жасын Дамдин хэмээн нэрлэдэг учир нь уг дээдэс жасын аймагт харьяалагддаг учир шалтгаанаас тэр болой. Мөн бүтэн нэрийг Дамдинжав хэмээн дууддаг байсан архивын баримт байна. Түүнийг хэлмэгдүүлэн байцаалт авсан тэмдэглэлээс үзэхэд зарим тэмдэглэлд Дамдин, зарим тэмдэглэлд Дамдинжав хэмээн зөрөөтэй бичсэн байна.

Монголын бурхны шашны төв Гандантэгчэнлин хийдийн Хансүр ринбүчи Ё.Амгалан ламын аман гэгээний айлдварт бидний сонссоноор дэд хамба Дамдин бол Бутач овогтой биш хэлмэгдүүлэх үед нь тааруу овог таацуулж бичсэн хэмээн айлдсан юм. Мөн Дамдин бол духан дээрээ Дамдин бурхны бэлгэдэлтэй гурван ногоон мэнгэтэй хүн байсан хэмээн Даяанч багшаасаа сонссон тухайгаа бидэнд хэлж аман мэдээ баримт өгсөн юм (2023 оны 4 дүгээр сарын 23 өдөр).

Жасын Цорж лам Дамдин аграмбын ном эрдмийн талаар олон чухал баримт байдгаас нэгийг нь дурдваас:

Сонгино (Сонгинохайрхан уулыг хэлж байна)-ыг даван баруунтайгаас үлийн цагаан оготнын нүүдэл ирж, Хүрээний газрын хөрс сүйтгэх аюул нүүрлэжээ. Засал гүрэм айлтгаж Наймдугаар Богдод мэдүүлсэнд, Дамдинд хэл гэсэн гэнэ. Богдын зарлигаар одоогийн Эх хүүхдийн эрүүл мэндийн төв эмнэлгийн хойд талд гэр бариулж, гаднаа гурилан муур хийлгэж тавиад гурав хоног ном уншин суужээ. Тэгээд гарч ирээд баруун тийш заан “Тэр үнэхээр бүтсэн оготно мөн бөгөөд чи үнэхээр бүтсэн муур мөн бол тэднийг барь” гэж хэд ороолгочихоод орж шөнөжин ном уншиж хонов гэнэ. Маргааш өглөө нь гараад хартал муурын ам нэл цус болчихсон, оготно сураггүй болсон байсан гэнэ. Энэ нь Буддын тарнийн гүн ухааны хөгжил манай оронд ямар хэмжээнд байсан, мөн Дамдин аграмба ямар эрдэмтэй хүн байсныг илтгэх зөвхөн ганц жишээ юм.

Хожим Дамдин аграмба хэлмэгдэн жанч халсны дараа 1937 оноос хойш эзэнгүй болж орхигдсон Зүүн хүрээний модон дуганууудаас Сн3-ийн 1939 оны 41-р хурлын тогтоолоор Улсын циркийн мэдэлд шилжүүлсэн 5 модон дуганы одоо циркийн сургууль байгаагаас бусад дөрвөн модон гэрийг Монголын архитекторуудын эвлэлийн мэдэлд шилжүүлэн сэргээх шийдийг Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор гаргасан. Тухайн үед хамгийн баруун талын том дуганыг (одоогийн циркийн сургууль) Их дагинын аймаг, зүүн урд талын агуулах байгаа том дуганыг Цэцэн тойны аймаг, зүүн хойд талын мөн агуулах байгаа нэг том, хоёр жижиг дуганыг Зоогой аймаг тус тус эзэмшиж байжээ. 1940 онд Улсын цирк байгуулагдахад циркийн мэдэлд шилжиж Их дагинын аймгийн дуганыг тоглолтын байр, бусад дуганыг агуулах болгон ашигласаар ирсэн байна [7].

Их хүрээ нь үндсэндээ Зүүн хүрээ болон, хүрээний баруун хэсэг болох Далхын дэнжид 1838 онд Тавдугаар Богдод зориулан байгуулсан Гандантэгчэнлин хийд гэсэн 2 хэсэг дүүрэгт хуваагдаж байжээ. Дэлгэрүүлэн дурдвал Их хүрээний төв дундахыг Зүүн хүрээ, Гандантэгчэнлин хийдийг тойрсон хүрээг Баруун хүрээ гэж нэрлэх болсон байна. Зүүн хүрээнд Батцагаан хэмээх цогчин дуган, Майдарын сүм, эмчийн, зурхайн, жүдийн, дүйнхорын зэрэг олон сүм дуганууд байжээ [8].

Аграмба Жасын Дамдин нь баригдан хэлмэгдэхийн өмнө Ёнзон хамба Лувсанхаймчогийн хувьсгалын эсэргүү “Төв” байгууллагын хэргээр 1937 оны 10 дугаар сарын 7-ны өдөр Дээд шүүхийн таслах газраа хуулийн дээд хэмжээгээр шийтгэгдсэн. БНМАУ-ын Улсын Дээд Шүүхийн Бүгд Хурлын 1990 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 7 дугаар тогтоолоор цагаатгаж иргэний нэр төрийг сэргээжээ.

Үнэн хэрэгтээ Зүүн хүрээг 1712 оны хар луу жил Өндөр гэгээн 78 насандаа байгуулсан бөгөөд Сангай, Зоогой, Дархан эмчийн аймгийг дотроо агуулдаг байжээ [9]. Тиймээс Өндөр гэгээний байгуулсан Зүүн хүрээний дархан эмчийн аймгийн эмчийн сургуульд “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”-ийг уншиж судалж байсан нь Энх-Амгалан хаантай машид ойр хамт байсан Өндөр гэгээний оролцоо зарлигийн тус дэм байх үндэслэл их хэмээн үзэж байна.

“Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”-ийн монгол хувилбар бол Өндөр гэгээний үед бүтээгдэж харин Наймдугаар богдын үед Зүүн хүрээний Мамба дацанд судлагдаж байсан нь түүхэн давхцалын зүй тогтолтой гэж үзэх үндэстэй юм [10].

Наймдугаар Богд хаан анагаах ухаан, одон орны зэрэг олон чиглэлийн мэдлэг ухааны номуудыг монгол хэлээр хөрвүүлэхийг зарлиг болгож байсан. Богдын зарлигаар “Эмийн найрлага, элдэв өвчнийг хялбар анагаахуй”, “Эмийн нэрс”, “Монгол, хятад хавсарсан нүдний эмийн найрлага”, “Нар, сар, од шинжих бичиг”, “Хүний биеийг шинжих бичиг” зэрэг анагаах ухааны олон ном судруудыг орчуулжээ.



Зураг 3. Дамдин маарамба

Мөн Наймдугаар Богд Жавзандамба хутагт монгол, төвөд, манж, хятад, уйгар таван хэлний толь бичгүүдийг захиалан “Хааны бичсэн, нэмж тогтоосон манж үгний толь бичиг” 40 дэвтрийг манжаас монгол хэлээр хөрвүүлүүлсэн байна. Мөн олон хэлний толь бичиг хийгээд дорно дахины олон хэлээр бичигдсэн 1223 орчим дэвтэр бичмэл ном Богд гэгээний номын санд байжээ.

“Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” бол анх Богд гэгээнд өргөгдөж түүнээс Зүүн хүрээний Мамба дацанд залагдсан байх үндэстэй юм. Учир нь Зүүн хүрээний Мамба дацангийн дэд хамба нь Да ринбүүчи, маарамба Дамдин байсан ажээ. Да ринбүүчи, маарамба болон Богдын гэгээн хоёр Богд гэгээний номын санд ордог өөр хүн ордоггүй байсан хэмээн Ф.Осседовский тэмдэглэн үлдээжээ. Уг номын сан нь Монголоос өөр улсад байхгүй маш ховор номын цуглуулгатай дэлхийд дээгүүрт орох номын сан байсан юм. Уг номын сангийн түлхүүр нь Богд хаанд Монгол төрийн тамга болон Чингис хааны бадмааараг шигтгээтэй алтан бөгжийн хамт эрдэнийн хайрцагт хадгалагдаж байжээ.

Зүүн хүрээний Сориг шанпанлин (Мамба дацан)-ийн багш, шавь нар Далхын дэнжийн хойд зүгт байрлах хүн тавьдаг газраас шарил (тухайн үед ил тавьдаг байв)-ыг тавьсан даруйд (үнэр орохоос өмнө) авч задлан шинжилж хүний биеийн бүтэц зүйг судлах үед ардуудын дунд гомдол яриа гарч улмаар Наймдугаар Богд Жавзандамба хутагтад энэ тухай өргөх бичиг барьсанд Богд хаан энэ асуудалд эмч нарыг “ил баалж, далд сайшаасан” бөгөөд “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээлийг сургалтдаа хэрэглэхийг зарлиг буулгажээ. Анх Далхын дэнж дээр 1809

онд Шар сүм нэртэйгээр Гандантэгчэнлин хийд болон Гандан дахь гэр хороолол үүсэх эхлэл нь тавигдсан бөгөөд эдүгээ Гандангийн дэнж хэмээн нэрлэдэг. Дээрх зарлигийг Богд хаан гаргахдаа:

1. Далхын дэнжийн хүн тавьдаг газраас шарил авч задлан шинжилж хүний биеийн бүтэц зүйг судлах хүсэлтэй Зүүн хүрээний Мамба дацангийн шавь нарт тус дөхөм болохыг бодолцжээ. Үүний учир юу гэвээс “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээлийн эхний ботийн 4 дэвтэр нь Европын анагаах ухааны биеийн бүтэц зүйн сонгодог мэдлэгийг багтаасанд оршино.
2. Шарил тавьсан даруйдаа алга болоод байна гэсэн ардуудын гомдлыг барагдуулах.
3. Маарамба Дамдин нь Зүүн хүрээний Мамба дацангийн дэд хамба, Да ринбүүчи байсны зэрэгцээ Богдын номын санд орох зөвшөөрөлтэй 2 хүний нэг нь бөгөөд “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг”-ийг хаана хадгалж байгааг сайн мэдэх тул Наймдугаар Богд Жавзандамба хутагтаас зөвшөөрөл авсан болох нь хэрэг явдлаас тодорхой байна.

Богд хааны номын сан нь 1924 он хүртэл Богдын шар ордонд байсан бөгөөд Богд хааныг таалал төгссөний дараа дотоод, гадаадын комментерний тонуулчдад тоногдон үрэгдэж зарим цөөн хэсэг нь л “Судар бичгийн хүрээлэн” буюу одоогийн Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж байна.

Үеийн үед эмч нар бол нийгмийн гол хөдөлгөгч хүч, ард олны дунд нэр хүнд өндөр байсан. Ард олны эрүүл мэнд гэдэг бол шууд утгаараа эх орон тусгаар тогтнолын үндэс болдог. Тиймээс ч Өндөр гэгээн хамгийн түрүүнд Монголд Дархан оточийн аймгийг байгуулсан юм [11].

1934 оны 11 дүгээр сарын 15-нд Монголын төлөөлөгчид болох П. Гэндэн, Х. Чойбалсан, Р. Мэнд, О. Дашчирав нарыг И. В. Сталин, В. М Молотов, К.Е. Ворошилов нар хүлээн авч уулзаад “... лам нар бол сүсэгтэн олны хувьд номын багш, төдийгүй, эмч оточ, гар үйлдвэрчин, зөвлөх нь байдаг. Тиймээс хамгийн түрүүнд лам нарын буюу уламжлалт анагаах ухааны нэр хүндийг унагах, гутаах, муу цуурхал тараах, европ эмнэлгийг сурталчлах зэрэг компанит ажил явуулахыг үүрэг өгсөн...”. Улмаар энэ үүргийг тун амжилттай хэрэгжүүлжээ.

Мөн 1935 онд Дотоодыг хамгаалах газрын дарга Д. Намсрайн бичсэн маш нууц зэрэглэлтэй 45 хуудас “Одоо үеийн Монгол Ард Улсын доторх лам нарын асуудлын тухай” номын 9-р зүйлд: “Төвөд эмнэлэг болбоос лам нарын зэвсэг мөн бөлгөө. *Үүнийг Европын шинжлэх ухааны эмнэлгээс ашиглаж ч болох зүйл буй амуй. Мөн энэ мэт саналыг одоо үед тус эмнэлгийг шинжлэхээр эвлэлдсэн СССР-ийн эрдэмтэн хүмүүс нараас ч ярьдаг бөлгөө. Иймхүү байдал нь чухамхүү юунаас ийм болгодог буй хэмээвээс:*

1. *Төвөд эмнэлэгт ашиг тус бүхий зүйл буй. Үүнийг дээр дурдсан бөгөөд хэрэв уг эмнэлгийг туршлага бүхий сайн лам эмч нараас зохих өвчинд тохирох эмийг найруулан тавьж хэрэглэх аваас үнэхээр элдэв өвчнийг анагааж чадах хүч бүхий болой. Иймд Төвөд эмнэлгийг бүрмөсөн зөрчих суртал нь ямар ч хүмүүний ухаанд орж үл болох хэрэг болой.*
2. *Төвөд эмнэлгээр анагааж гүйцэтгэсэн ололттой зүйл нь ... хэрэгт тус дөхөм болж байна.*
3. *Одоо үед ард нийт нь Төвөд эмнэлгийг өөрчлөн хэрэглэсээр буй тул лам нарын нэр хүнд хэвээр буйгаас гадна эдүгээ үед Европын эмнэлгийн салбар ба эмч нар нь ард нийтэд дүүрнээр хүрэлцүүлэхээр байгуулагдаж чадахгүй байна.*

Европ эмнэлгийн эмч нар нь гол төлөв орос хүмүүс болох тул хэл ба ардын заншил байдал зэрэг Монголын ард түмний онцгой байдлыг мэдэхгүй дутагдлууд буй бөгөөд ер нь ч энэхүү дээр дурдсан Европын эмнэлгийн салбар ба ажилчдын тоог тус хотын Гандан хүрээний Мамба дацангийн 300 гаруй эмч нар хийгээд мөн улсын доторх хэдэн мянган эмч нар лугаа адилтгаж үзвээс Европын эмнэлгийн салбар ажилчид нараар дутмаг байсныг илэрхийгээр үзүүлэх болмуй.”

Лам нар лугаа онолын ба сургалтын талаар тэмцэх арга хэмжээг тодорхойлохдоо: “Энэхүү дээр дурдсан зүйлсээс үзвээс тус улсын дотор манлайлан буй Төвөд эмнэлэг нь Европын эмнэлгээр бүрмөсөн хавчигдан зайлах явдал нь нэлээд аажим буй” гэжээ. Энэхүү нууц номны зөвлөгөөнөөс болж эмч маарамба нарын хэлмэгдлийг хүчээр шууд эхлүүлэх нөхцөл заавар болсон байна [12].

Улмаар 1937 оноос өмнө 1, 1937 онд 1, 1938 онд 355 маарамбыг хилс хэрэгт гүтгэн амийг нь егүүтгэжээ. Маарамбаас гадна эмч, оточ албан тушаалтай 4 хүн нийт 359 уламжлалт анагаах ухааны боловсон хүчин болсон соёлын өвийг тээгчдийг хэлмэгдүүлэн егүүтгэсэн байна [13]. Тагнуулын ерөнхий газрын тусгай архивын Сх-1. Хн-437, тал-25-д тэмдэглэгдснээр 1937 оны бүртгэлээр Хөвсгөл, Ховд, Увс, Завхан зэрэг аймгаас бусад аймгуудад 1254 эмч лам нар байжээ.

Жамъян гүн, Судар бичгийн хүрээлэнгийн дарга байх хугацаанд 1921-1930 оны хооронд “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” судрыг Зүүн хүрээнээс авч чадаагүй бөгөөд 1938 онд Жасын Дамдинжав аграмбыг хэлмэгдүүлэн буудуулж жанч халсны дараа нь ном судрыг нь Улсын номын санд авчээ. Үүний зэрэгцээ 1942 онд МУИС -ийн анагаах ухааны факультет байгуулагдсаны дараа Зүүн хүрээний Мамба дацангаас цэнхэр хавтастай 6 дэвтэр “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” [14], гавал аяга, гавал эрхи, Европ зүгийн хийцтэй хүний анатомийн муляж зэргийг шилжүүлэн авсан байна. Дашрамд дурдахад шашны жаяг ёсны дагууд гавал аяга, гавал эрхи бол аграмба хүний хэрэглэгдэхүүн байдаг бөгөөд энэ нандин эд өлгийн зүйлс Жасын Дамдин аграмбынх байх өндөр магадлалтай байна.

Харин МУИС-ийн Анагаах ухааны факультетид өгсөн, Зүүн хүрээнээс ирсэн анатомийн муляжийн гарал үүсэл бол 1911 оны Монгол, Оросын хооронд Найрамдлын гэрээ байгуулсан Орос улсын бүрэн эрхт элчин И.Я.Коростовецийн тэмдэглэлд бичигдсэнчлэн: “... Биднийг хоёр давхрын европ мебель болон хятад вааран эдлэл цуглуулгаар дүүргэсэн зааланд авчрав. Энэ заалны үүдэн хэсэгт анатомийн музейн хүний моделийг босгож ...” хэмээн өгүүлжээ [15].

Мөн Larson Duke of Mongolia by Prans August Larson (Boston, 1930) гэдэг номд: Швед гаралтай Ларсон Богдын талаар бичихдээ: *“Би анх удаа Амьд бурхантай 1894 онд уулзсан ... тэрбээр гадаад явж чадахгүй учраас Стокгольм, Берлин, Лондон, Парис, Ром, Нью Иоркийн дэлгүүрийн барааны каталогийг авдаг байсныг мэдэв. Тэрбээр хүссэн бараанаас нэг нэгийг захиалан авчруулж, Туул голд буй ордондоо гадаадын сайн бүхнийг хураадаг ... .”* [16] гэсэн нь хааны ордон дахь анатомийн моделийн гарал үүслийг тодорхойлсон эх сурвалж бололтой. Үүнээс үзэхэд бид Наймдугаар Богд Жавзандамба хутагт хааны таалал хийгээд “Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээлээр л гэхэд хэрхэн орчин үеийн анагаах ухааны ололт амжилтаас хоцролгүй хөл нийлүүлэн хөгжихийг хичээн зүтгэж байсныг илтгэж байна.

Дүгнэлт

“Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээлийн 2 боть, 6 дэвтрийг нийлүүлэн 1971 онд хэвлүүлсэн хэвлэлийн өмнөх үгдээ Б.Ринчен гуай Улаанбаатарт хадгалан буй эзнийг нь гэж нэр заалгүй, тодорхой бус дурдсан хүн нь Зүүн хүрээний Мамба дацангийн дэд хамба, Да ринбүчи хэмээн алдаршсан Жасын Дамдин аграмба (маарамба) байжээ гэдгийг тодруулан гаргав.

Наран гэрэлт, түмэн наст Наймдугаар Богд Жавзандамба хутагт хааны зарлиг, Жасын Дамдин аграмба (маарамба)-ын ачаар анагаах ухааны энэ чухал судар Монгол Улсад Мамба дацангаар эмч бэлтгэх сургалтад ашиглагдаж, уг бүтээлд бичсэн тухайн үеийн Европт нээгдсэн анагаахын шинжлэх ухааны ололт амжилтыг эмчийн сургуульд суралцагсад, шавь нарт заан сургах, улмаар Өрнө, Дорно анагаах ухааныг интеграцичлах удаа дараагийн оролдлогын бас нэг чухал баримт болсон хэмээн үзэж байна.

Ном зүй

1. Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг. Эрхэлсэн проф. др. Ринчен. Corpus Scriptorum Mongolorum, Tomus XVII, Fasciculus I, x.3-4
2. Машлай Т. Studia mongolica instituti linguae et litterarum akademiae scientiarum reipublicae populi mongoli. Tomus VI. Fasc 7. Онходын Жамьянгийн товч намтар ба үйл ажиллагаа. Улаанбаатар, 1967, x.69.
3. Сонинбаяр Ш. Монголын төрөөс шашны талаар явуулсан бодлого, баримт судалгаа, Лам нар сүм хийдийн хэлмэгдэл ба цагаатгал, ЭШБХ-ын эмхэтгэл. Улаанбаатар, 2008, x.41-46.

4. Чоймаа Ш. Онходын Жамъян гүн. https://aygatsai.com
5. Амгалан Ё. Сүсгийг дэвэлгэх эрдэнийн хумх баригч номч мэргэн дияанч лам Лувсанбалдан. Улаанбаатар, 2006, х.31.
6. Цэдмаа Д. Дурсамж дүүрэн музей. Улаанбаатар, 2014, х.8.
7. Өлзий Ж. Монголын дурсгалт уран барилгын түүхээс. Улаанбаатар, 1992, х.81.
8. Дамбажав Ч. Хутагтын их хүрээ хийгээд Нийслэл хүрээ. Нийслэл хүрээ 100 жил эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2012, х.58.
9. Өндөр гэгээний намтар. Хуучин монгол бичгээр, х.8
10. Гэрэлмаа Б. “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг сурвалжийн эх бичгийн судалгаа” анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар, 2020, х.45-47
11. Монголын сүүлчийн эзэн хаан 8-р Богд Жавзандамба хутагт. х.6.
12. Их хүрээний гучин аймаг. Дэлгэржаргал П., Нямдорж С., Батдорж С., Лхагвабаяр Б. Эмхэтгэсэн Зүүн хүрээ Дашчойлин хийд, Монгол Улсын их сургууль, Түүхийн тэнхим. Бичиг баримтын эмхэтгэл. 1651-1938 он. Улаанбаатар, 2015, х.199-200.
3. Эрдэнэсайхан А. Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон, Лам нарыг егүүтгэсний учир 16-р боть, улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгал “Цагаан ном”-ын хавсралт, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төв. Улаанбаатар, 2013, х.10,59,151,166.
4. Гэрэлмаа Б. Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг сурвалжийн уг гарал, агуулга, арга зүйн үндэс. Улаанбаатар, 2022, х.47.
5. Батсайхан О. Дээрхийн уг эх наймдугаар дэвтэр, Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт (Амьдрал ба домог). Улаанбаатар, Соёмбо принтинг, 2019, х.269-270.
6. I-IX Богдууд. Их Оюунлаг хүн сэтгүүл. Цуврал 19. Улаанбаатар, 2013, х.28,29